



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/78

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1.2, 3.4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймаг, Оросын Холбооны улсын Красноярск хязгаартай байгуулсан хамтын ажиллагаа санамж бичгийн хүрээнд тус хязгаарын аялал жуулчлалын холбооны төлөөлөгчдийг хүлээн авах, хамтарсан гэрээ байгуулах үйл ажиллагааны зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээр тусгагдсан зардал болох 4,011,000 (дөрвөн сая арван нэгэн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0170

Аймгийн Засаг даргын 2023 оны... дугаар
сарын ...-ны өдрийн ... дүгээр
захирамжийн хавсралт



**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН КРАСНОЯРАСК ХЯЗГААРЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ
ХҮЛЭЭН АВАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Арга хэмжээ	Хүний тоо	Хоног	Нэг бүрийн үнэ (мянга)	Нийт дүн
1	Байрлах байрны зардал	8	2	110,437	1.767.000
2	Хоолны зардал	8	3	93.500	2.244.000
Нийт дүн					4.011.000

/3 эрэгтэй, 5 эмэгтэй /

--oOo--